



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2014 оны 03 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$1,983 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 1,982.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.6%-иар буюу 31.3 сая ам.доллараар буурчээ. Үүнд экспорт 177.7 сая ам.доллараар өссөн хэдий ч импорт 209.1 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 56% буюу 1,117.1 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 16% буюу 312.1 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 9%-иар өссөн бол, ОХУ-тай хийсэн худалдаа 2%-иар буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -\$9 сая

Мөнгөн дүн 2014 оны эхний 3 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл -9.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 97.7%-иар буюу 386.8 сая ам.доллараар буурчээ. Энэ нь экспорт 22.0%-иар өссөн, импорт 17.3%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан бол 2014 оны эхнээс өсөх хандлага руу орсон. Энэ нь оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсантай холбоотой байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: +\$37.8 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшинд нөлөөлдөг суурь үзүүлэлт юм.

Энэхүү үзүүлэлт 2014 оны эхний 3 сард +37.8 сая ам.долларт хүрлээ. Үүнд валютын төлбөртэй импортын дүн 14.0%-иар буурсан, экспортын дүн 20.1%-иар өссөн нь нөлөөлөв.

Гадаад худалдааны нөхцөл: 1.473

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.473-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.1%-иар өссөн нь 2012 оны 1 дүгээр сараас хойш гарсан анх удаагийн эерэг өсөлт боллоо.


Үүнд нефтийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн орцын импортын хилийн үнэ буурч, зэсийн баяжмал, чулуун нүүрс, төмрийн хүдэр зэрэг голлох экспортын бүтээгдэхүүний хилийн үнэ өссөн нь нөлөөлжээ.

Ялангуяа нийт экспортын 25 орчим хувийг бүрдүүлж буй зэсийн баяжмалын хилийн үнэ оны эхнээс 18%-иар өссөн нь экспортын үнийн индекс өнгөрсөн оны мөн үеэс 8%-иар өсөхөд голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 3 сар			Өөрчлөлт			
	2014	2013	2012	2014/2013		2013/2012	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	1,982.9	2,014.2	2,335.7	(31.3)	-1.6%	(321.5)	-13.8%
Экспорт	986.9	809.2	877.8	177.7	22.0%	(68.6)	-7.8%
Импорт	996.0	1,205.0	1,457.9	(209.1)	-17.3%	(252.9)	-17.3%
Тэнцэл	(9.1)	(395.8)	(580.1)	386.8	-97.7%	184.3	-31.8%

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцлийн индексийн өөрчлөлт



Бүтэц: 93%+ 7%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өсч нийт экспортын 93%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 87%, нийт экспортын 80%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 1.2 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 1.6 нэгж хувиар өссөн байна.

Өсөлт: +22.0%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 22.0%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 21.1%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал, боловсруулаагүй нефть, мөнгөжөөгүй алтны экспортын өсөлтүүд нь уг бүлгийн өсөлтийн 34%-ийг бүрдүүлжээ. Харин төмрийн хүдэр болон цайрын баяжмалын экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 35%, 66%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 10%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 185.8 сая ам.доллараар өссөн бол үнийн бууралтаас шалтгаалж 8.1 сая ам.доллараар буурснаар нийтдээ 177.7 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал, боловсруулаагүй нефть, мөнгөжөөгүй алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 219 сая ам.доллараар өсөх нөлөө үзүүлсэн бол төмрийн хүдэр, цайрын экспортын тоо хэмжээ буурснаас, мөн чулуун нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 94 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын хувьд үнийн дүн өссөн хэдий ч тоо хэмжээ буурснаар өмнөх оны мөн үеэс харгалзан 0.9 сая ам.доллараар буурсан байна.

Бусад экспортын хувьд үнийн дүн болон тоо хэмжээ зэрэг өссөнөөр өмнөх оны мөн үеэс 8 сая ам.доллараар өссөн.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2014 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар унц тутамд 1,284.0-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 19.6%-иар, өмнөх сараас 3.2%-иар буурсан байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2014 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 6,650.0, 1,970.3 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 6.1%-иар, цайр 6.7%-иар тус тус буурсан бол, өмнөх жилийн мөн үеэс зэс 11.4%-иар буурч цайр 5.7%-иар өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2014			2013			Өөрчлөлт		
	Тоо хэмжээ (МЯН.ТН.КГ)	Дүн	%	Тоо хэмжээ (МЯН.ТН.КГ)	Дүн	%	Дүн	%	% 2
1. Ашигт малтмал	918	93%		748	92%		170	↑ 23%	21.1%
Чулуун нүүрс	3,735	206	2%	3,445	209	26%	(3)	↓ -1%	0%
Зэсийн баяжмал	214	349	35%	140	209	26%	140	↑ 67%	19%
Төмрийн хүдэр/баяжмал	909	81	8%	1,22	126	16%	(44)	↓ -35%	-6%
Боловсруулаагүй нефть	1,608	158	16%	982	94	12%	64	↑ 68%	9%
Цайрын үдэр ба баяжмал	5	15	1%	42	43	5%	(28)	↓ -66%	-4%
Мөнгөжөөгүй алт	2,171	90	9%	1,020	43	5%	47	↑ 110%	6%
Жонц, лейцит, нефелинт	56	12	1%	64	5	2%	(3)	↓ -20%	0%
Молибдений хүдэр/баяжмал	1	7	1%	1	9	1%	(1)	↓ -1%	0%
2. Ноос, ноолуур	5.7	1%		6.6	1%		(1)	↓ -14%	0%
Ямааны угаан ноолуур	43	2	0%	48	2	0%	(0.2)	↓ -11%	-3%
Ямааны самноолуур	39	4	0%	53	5	1%	(0.7)	↓ -14%	-1%
3. Бусад	63	6%		55	7%		8	↑ 15%	1%
Нийт дүн	987			809			177.7	↑ 22.0%	

%2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
		%		%		%
1. Ашигт малтмал	183		(12)		170	
Чулуун нүүрс	18	-564%	(21)	664%	(3)	-1%
Зэсийн баяжмал	111	79%	29	21%	140	67%
Төмрийн хүдэр ба баяжмал	(24)	54%	(21)	46%	(44)	-35%
Боловсруулаагүй нефть	60	94%	4	6%	64	68%
Цайрын үдэр ба баяжмал	(28)	98%	(1)	2%	(28)	-66%
Мөнгөжөөгүй алт	48	102%	(1)	-2%	47	110%
Жонц, лейцит, нефелинт	(2)	66%	(1)	34%	(3)	-20%
Молибдений хүдэр ба баяжмал	(0)	20%	(1)	80%	(1)	-16%
2. Ноос, ноолуур	(15)		0.6		(0.9)	
Ямааны угаан ноолуур	(0.2)	98%	(0.0)	2%	(0.2)	-1%
Ямааны самсан ноолуур	(13)	184%	0.6	-84%	(0.7)	-14%
3. Бусад	5	56%	4	44%	8	15%
Нийт	185.8		(8.1)		177.7	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнэ



Бүтэц: 20% + 23%

2014 оны эхний 3 сарын байдлаар нийт импортын 43%-ийг үйлдвэрлэлийн орц болон нефтийн бүтээгдэхүүн, 14%-ийг өргөн хэрэглээ, 4%-ийг хүнсний бараа, үлдсэн 38%-ийг бусад төрлийн импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

Үйлдвэрлэлийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 12%-иар буурсанд нефтийн импортын хувийн жин 5%-иар, үйлдвэрлэлийн орцны хувийн жин 7%-иар тус тус буурсан нь нөлөөлжээ. Харин өргөн хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь өмнөх жилийн мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.

Өсөлт: -17.3%

Импортын 17.3%-ийн бууралтыг ерөнхий ангиллаар задалвал үйлдвэрлэлийн орцын бууралт нь 10%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт 8%-ийг тус тус тайлбарлаж байна.

Үйлдвэрлэлийн орц өмнөх оноос 38%-иар буюу 122 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 30%-иар буюу 100 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 17.3%-иар буурахад голлон нөлөөлжээ.

Өөрчлөлт

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад импорт нь тоо хэмжээний бууралтаас шалтгаалан 60.4 сая ам.доллараар, үнийн дүнгийн бууралтаас шалтгаалан 148.6 сая ам.доллараар, нийт дүнгээр 209.1 сая ам.доллараар буурчээ.

Нефтийн бүтээгдэхүүний импорт тоо хэмжээ нь буурснаас шалтгаалан 83.7 сая ам.доллараар, хилийн үнийн бууралттай холбоотойгоор үнийн дүн нь 31.3 сая ам.доллараар буурснаар нийт 115.1 сая ам.доллараар буурсан байна. Дүрслэл 6-с үзэхэд хилийн үнэ 2012 оны эхнээс буурч, 8 сараас өсөх хандлагатай байсан хэдий ч 2013 оны 10 дугаар сараас эхлэн буцаад буурч байна.

Үйлдвэрлэлийн орцын үнийн дүнгийн бууралтаас шалтгаалж нийт дүнгээр 122.0 сая ам.доллараар буурсан байна. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 5.4 сая ам.доллараар өссөн ч үнийн дүнгийн бууралтаас шалтгаалж нийт дүнгээрээ 5.8 сая ам.доллараар буурчээ.

Зарим хэрэглээний барааны импорт*

Голлох хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст – 4%-д хүрч буурсан байна.

Цахилгаан барааны жилийн өсөлтийн хувьд 2012 оны дунд үеэс буурч байсан хэдий ч 2013 оны 8 дугаар сараас эхлэн өөрчлөлт багатай, тогтвортой байсан. Гэвч сүүлийн сарын нөлөөгөөр энэ үзүүлэлт өсөх хандлагатай болсон. Харин суудлын автомашины импортын өсөлтийн түвшин 2013 оны 8 дугаар сараас эхлэн буурах хандлагатай байна. Ингэснээр нийт өргөн хэрэглээний импорт 2013 оны 8 дугаар сараас эхлэн буураад байна.

* Нийт импортын 70%-ийг бүрдүүлдэг 136 бүтээгдэхүүнээс өргөн хэрэглээний гэсэн 48 бүтээгдэхүүний хувьд тооцоолов.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2014			2013			Өөрчлөлт		
	Тоо/хэм (тн.мян.ш)	Дүн	%	Тоо/хэм (тн.мян.ш)	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2
Үйлдвэрлэлийн орц		203	20%		325	27%	(122)	-38%	-10%
Хүнд механизм, тоног төх.	6,163	118	58%	3,483	189	58%	(71)	-37%	-22%
Суудлаас бусад автомашин	187	53	26%	201	109	33%	(56)	-51%	-17%
Төмөр хийц, металл бүт.	5,545	8	4%	6,127	9	3%	(1)	-12%	0%
Бусад бүтээгдэхүүн	126,404	24	12%	113,772	18	6%	6	31%	2%
Нефть		232	23%		332	28%	(100)	-30%	-8%
Дизель түлш	109,285	119	51%	167,030	209	63%	(90)	-43%	-27%
АИ-92, АИ-95	70,290	78	34%	52,368	66	20%	9	17%	3%
А-80 болон бусад	29,846	35	15%	43,320	57	17%	(21)	-38%	-6%
Өргөн хэрэглээ		141	14%		147	12%	(6)	-4%	0%
Суудлын автомашин	9	65	46%	9	76	52%	(11)	-14%	-7%
Цахилгаан бараа	692	32	22%	270	28	19%	4	15%	3%
Бүх төрлийн эм	400	15	11%	392	13	9%	3	20%	2%
Бусад өргөн хэрэглээний	6,160	29	20%	3,618	31	21%	(2)	-6%	-1%
Хүнс		42	4%		35	3%	7	18%	1%
Гурил, будаа, талх	16,683	12	29%	9,423	10	28%	2	24%	7%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	1,120	6	14%	1,166	4	11%	2	48%	5%
Төрөл бүрийн өөх тос	5,722	7	16%	5,539	7	21%	(1)	-7%	-2%
Согтууруулах ундаа	3,653	4	9%	4,260	4	11%	(0)	-3%	0%
Хүнсний ногоо	14,131	4	10%	17,453	3	9%	1	23%	2%
Бусад	13,824	9	22%	13,544	7	20%	2	31%	6%
Бусад импорт		378	38%		366	30%	12	3%	1%
Бусад		378			366		12	3%	3%
Нийт дүн		996			1,205		(209)	-17.3%	

%2 - өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Хүснэгт 5. Импортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн дүнгийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн дүнгийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Үйлдвэрлэлийн орц	0.1	0%	(122.2)	100%	(122.0)	
Хүнд механизм, тоног төх.	27.3	-39%	(98.0)	139%	(70.8)	-37%
Суудлаас бусад автомашин	(25.5)	46%	(30.4)	54%	(55.9)	-51%
Төмөр хийц, металл бүт.	(0.7)	67%	(0.4)	33%	(1.1)	-12%
Бусад бүтээгдэхүүн	(0.9)	-16%	6.6	116%	5.7	31%
Нефть	(83.7)	73%	(31.3)	27%	(115.1)	
Дизель түлш	(72.1)	80%	(17.6)	20%	(89.7)	-43%
АИ-92, АИ-95	22.7	200%	(11.4)	-100%	11.4	17%
А-80 болон бусад	(34.3)	94%	(2.4)	6%	(36.7)	-38%
Өргөн хэрэглээ	5.4	-94%	(11.2)	194%	(5.8)	
Суудлын автомашин	(6.9)	65%	(3.7)	35%	(10.5)	-14%
Цахилгаан бараа	12.4	303%	(8.3)	-203%	4.1	15%
Бүх төрлийн эм	0.3	11%	2.3	89%	2.5	20%
Бусад өргөн хэрэглээний	(0.4)	20%	(1.5)	80%	(1.9)	-6%
Хүнс	1.5	24%	5.0	76%	6.5	
Гурил, будаа, талх	(0.1)	-4%	2.5	104%	2.4	24%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	(0.1)	-7%	2.0	107%	1.9	48%
Төрөл бүрийн өөх тос	0.7	-126%	(1.2)	226%	(0.5)	-7%
Согтууруулах ундаа	0.1	-52%	(0.2)	152%	(0.1)	-3%
Хүнсний ногоо	0.4	52%	0.4	48%	0.7	23%
Бусад	0.6	28%	1.6	72%	2.2	31%
Бусад импорт	16.2	59%	11.2	41%	27.3	
Бусад	16.2	59%	11.2	41%	27.3	3%
Нийт дүн	(60.4)		(148.6)		(209.1)	

Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж*/

